

Бүс нутгийн бүсшил нь даяаршлын нэг хэсэг үү эсвэл түүний альтернатив уу?

Б.Билэгжаргал*

Товч утга: Бүс нутгийн бүсшил болон даяаршлын талаар судлаачид ямар байр суурьтай байдаг мөн эдгээр хоёр үйл явцын нийтлэг болон ялгаатай шинж чанаруудыг авч үзлээ.

Түлхүүр үгс: бүс нутгийн бүсшил, даяаршил, олон улсын харилцаа, хамтын ажиллагаа, цэрэг-улс төрийн бүлэглэл, эдийн засгийн бүлэглэл.

Abstract: This article deals with the regionalization and the globalization, researchers' points of view concerning these two terms and tries to find out common and different features of these two processes.

* * *

Орчин цагт дэлхийн улс гүрнүүд хөгжлийн асуудал дээр хамтын ажиллагааг эрхэмлэдэг бөгөөд аливаа нэгэн асуудлыг мөн хамтран шийдвэрлэдэг болсон билээ. Ийм нөхцөлд тухайн бүс нутгийн геополитик, гео-эдийн засгийн кодыг хамгийн зөв ашигласан нэгэн л амжилтанд хүрнэ. Дэлхийн II дайны дараа улс орнууд даяаршил, бүс нутгийн бүсшил гэсэн хоёр нөхцөлд оршин тогтнох болсон. Эдгээр үйл явцууд нь дэлхийн эдийн засгийн байдалд асар их нөлөөлөөд зогсохгүй, улс төр, нийгэм, соёлын хүрээнд ч үр дагавараа үзүүлж байна.

Энэхүү хоёр үзэгдлийг тайлбарласан нэгдсэн тодорхойлолт өнөөдрийн байдлаар байхгүй байгаа учир зарим толь бичигт гарсан мэдээллийг жишээ болгон орууллаа.

* Олон улсын харилцаа, бүс нутаг судлаач. Магистр.

Даяаршил

“Globalization - the fact that different cultures and economic systems around the world are becoming connected and similar to each other because of the influence of large multinational companies and of improved communication.”¹

(Даяаршил – харилцаа холбооны өндөр хөгжил болон олон улсын том компаниуд, байгууллагуудын нөлөөн дор дэлхийн олон соёл болон эдийн засгийн системүүд хоорондоо холбоотой, ижил төстэй болох үйл явц юм.)

Хэдийгээр судлаачид даяаршлын агуулгыг өөр өөрөөр тайлбарлаж байгаа ч гэсэн дараах мөн чанаруудыг олонхи нь хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Дэлхийн хүрээнд нэгдмэл дүрэм журмын дагуу хэрэгждэг эдийн засгийн систем бий болох хандлага;
- Улсуудын эдийн засаг, улс төр, мэдээллийн гадаад болон дотоод бодлого, үйл ажиллагаа хоорондын ялгаа, хязгаар арилах төлөв;
- Барууны амьдрал, аж ахуйн стандарт дэлхийн бусад орнуудад нэвтрэх зэрэг орно.

Даяаршлын үүслийн талаар нэгдсэн үзэл бодол байдаггүй билээ. Түүхчид үүнийг капитализмын нэгэн үе шаттай, улс төрчид ардчилалтай, эдийн засагчид олон улсын санхүүгийн зах зээл үүссэнтэй, соёл судлаачид барууны нөлөөлөл ихссэнтэй холбоотой гэж үзэх нь бий. Гэсэн хэдий ч судлаачдын олонхи нь даяаршлыг эдийн засгийн либералчлалын нөлөөн дор үүсч буй олон улсын харилцаан дахь болон дэлхийн эдийн засгийн чанарын өөрчлөлтийг харуулсан үйл явц гэж тодорхойлдог.²

1. <http://www.oxforddictionaries.com>

2. “General Analysis on Globalization of the Economy”, Global Policy Forum, 2013, www.globalpolicy.org

Бүс нутгийн бүсшил нь даяаршлын нэг хэсэг үү эсвэл түүний альтернатив уу?

Бүс нутгийн бүсшил

Бүс нутгийн бүсшил өнөө үед олон улсын харилцаанд чухал ач холбогдолтой болоод байгаа билээ. Ялангуяа эдийн засгийн харилцааны хүрээнд илрэлээ олоод байгаа (хамтын бизнес эрхлэлт, хил дамнасан хамтын ажиллагаа г.м.) бөгөөд энэ нь тодорхой улс орнуудын өрсөлдөх чадвараа дээшлүүлэн сайжруулах зорилготой холбоотой.

Бүс нутгийн бүсшил үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд: нэгдүгээрт бүс нутгийн аюулгүй байдлыг хангах зорилготой цэрэг-улс төрийн бүлэглэл, хоёрдугаарт улс орныхоо өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дэлхийн эдийн засагт эзлэх байр сууриа улам бэхжүүлэхийн тулд үүсгэдэг эдийн засгийн бүлэглэл багтдаг.³

Цэрэг, эдийн засаг, улс төрийн хүчээрээ тэргүүлдэг улс гүрнүүдийг хүрээлэн бий болсон бүс нутаг өнөөдөр хамгийн амжилттай хөгжиж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний зарим жишээ нь Баруун Европ, Зүүн Азийн улс орнууд юм.⁴ Дэлхийн зарим улс гүрнүүд шинэ зах зээлүүдийг эзэлж улмаар олон улсын тавцанд нөлөөгөө тогтоохыг эрмэлзэн бүс нутагт нэгдэн хамтардаг бол нөгөө хэсэг орнууд нь хөгжингүй улсуудаас өөрийгөө хамгаалах зорилготой холбоо байгуулдаг.

Бүс нутгийн бүсшил болон бүс нутаг судлал талаар мөн л нэгдсэн тодорхойлолт одоо хүртэл байдаггүй. Тиймээс толь бичигт гарсан зарим жишээг авч үзье:

“Regionalization - the way that an area of the world containing several countries becomes more economically or politically important than the particular countries within that area.”⁵ (Бүс нутгийн бүсшил – тодорхой бүс нутаг нь тус бүс нутагт оршдог аливаа нэг улсаас эдийн засаг болон улс төрийн хувьд илүү чухал ач холбогдолтой болох явц юм.) Энэхүү үзэгдэл нь дэлхийн олон улсуудад илрэлээ олоод байгаа билээ.⁶

3. Сборник трудов молодых ученых : Вып. 7 / Моск. гос. ун-т им. М. В. Ломоносова, Фак. иностр. яз. и регионоведения М. : Изд-во Моск. ун-та, 2012, с.53.

4. “Regionalization vs. Globalization”, International Monetary Fund, January 22, 2013, www.imf.org

5. <http://dictionary.cambridge.org>

6. La regionalisation en Europe, Gerard Marcou, University Paris I Pantheon-Sorbonne, 1999, P. 7

Энэхүү үйл явцын тухай судлаачид олон янзын бодолтой байдаг хэдий ч ихэнх нь дараах зүйлүүдийг бүс нутгийн бүсшилтэй холбоотой гэж үздэг. Үүнд:

- Хамтран ажлаж буй улсууд нь өөр хоорондоо хөнгөлөлтэй нөхцөлтэйгөөр худалдаа эрхлэх.
- Тухайн бүс нутаг болон түүний гишүүн улсууд нь дэлхийн чухал зах зээлүүдэд өөрийн нөлөөллийг тогтоохыг эрмэлздэг.
- Хөрш орнуудад нийгмийн амьдралд амар тайван бус байдал үүсэх, улмаар цагаачлах иргэдийн тоо өсөхөөс сэргийлэн хөрш улс орнуудынхаа хөгжил цэцэглэлтэд нь тус нэмэр болох явдал.
- Эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааг дагаад улс хоорондын соёлын харилцаанд ч өөрчлөлт ордог.

Даяаршил ба бүс нутгийн бүсшилийн харилцан хамаарал

Бүс нутгийн бүсшил болон даяаршил хоорондоо ямар холбоотой, бие биенээсээ хэрхэн хамааралтай гэдэг нь өнөөдөр маргаантай байгаа асуудал юм. Үүний талаар их хэмжээний судалгаа хийгдэж байгаа ч гэсэн одоог хүртэл тодорхой нэг дүгнэлтэд хүрээгүй болно. Учир нь зарим судлаачид бүс нутгийн бүсшилийг даяаршилд хүргэх алхам, даяаршлын эхний үе шат хэмээн үздэг бол нөгөө хэсэг нь үүнийг даяаршлын эсрэг бий болсон үйл явц буюу улсууд бүс нутагт нэгдэн гадны сөрөг нөлөөнөөс өөрсдийнхөө эдийн засаг, соёл болон улс төрийн байдлаа хамгаалах зорилготой үүсгэсэн нэгдэл гэж тодорхойлдог.⁷

Нэг талаас бүс нутгийн бүсшил нь даяаршлын нэг хэсэг гэж үзэх нь үндэслэлтэй бөгөөд уг хоёр үзэгдэл дараах ижил уг чанартай байдаг. Үүнд:

Аливаа нэгэн нэгдлийн хүрээнд хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулснаар асуудал, маргаан шийдвэрлэхэд шаардагдах механизмуудыг хайж олох, олон төрлийн нийгмийн бүлгүүдийн үзэл бодол, сонирхлыг илэрхийлэх институтууд байгуулах асуудалтай тулгардаг.

7. "Regionalization vs. Globalization", International Monetary Fund, January 22, 2013, www.imf.org

Бүс нутгийн бүсшил нь даяаршлын нэг хэсэг үү эсвэл түүний альтернатив уу?

- Хамтран ажиллаж буй улсууд нь хоорондоо хөнгөлөлттэй нөхцөлтэй худалдааны үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог.
- Улс хоорондын соёлын харилцаа тэлж, өөр нийгмийн амьдрал, аж ахуй, ёс заншилтай танилцсанаар иргэдийн харилцаа холбоо бэхждэг.
- Боловсролын салбарт сурагч, оюутан, багш нарыг хамарсан улс хоорондын хөтөлбөр, үйл ажиллагаа идэвхждэг.
- Иймээс эдгээр шинж чанаруудыг үндэслэн даяаршил бүс нутгийн бүсшил хоёр нь ижил зорилготой, төстэй үйл явцууд гэж тодорхойлж болно. Гагцхүү бүс нутгийн бүсшилийн хамрах хүрээ буюу оролцогч улсуудын тоо хязгаар бага л болохоос энэ нь угтаа даяаршил гэж үздэг.
- Нөгөө талаас бүс нутгийн бүсшил тодорхой бүлэгт нэгдсэн улс орнууд даяаршлын эсрэг тэмцэж, эдийн засаг, улс төр, соёлоо хамгаалах зорилготой бий болгосон үйл явц хэмээн тодорхойлдог. 8 Иймээс бүс нутгийн бүсшилийн үйл явцад дараах мөн чанарууд хамааралтай гэж үзэж болно:
- Нэг бүс нутгийн хүрээнд хамтын үйл ажиллагаа явуулж байгаа гишүүн-улсуудын тус нэгдэлд хамааралгүй улс орнуудтай эдийн засаг, улс төр, соёлын салбар дахь харилцаа нь багасдаг. Үүний үр дүнд тухайн бүс нутгийн нэгдэлд хамааралгүй улсуудтай тохиролцох, буулт хийх нь хүндрэлтэй болж улмаар улс хоорондын ялгаа, саланги байдал гүнзгийрч, олон улсын харилцаанд сөргөөр нөлөөлдөг байна.
- Аливаа улсын ямар нэгэн бүс нутгийн бүрэлдэхүүнд орох нь газар зүйн байршил гэхээс илүү эдийн засгийн сонирхолтой холбоотой байдаг ба үүний үр дүнд дэлхийн орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшний ялгаа ихэсдэг.
- Зөвхөн тухайн бүс нутгийн хүрээнд гишүүн-улсууд хоорондоо эдийн засгийн хөнгөлөлт эдэлдэг нь бусад орнуудын хувьд тэгш бус байдлыг үүсгэдэг.
- Нэг бүс нутгийн гишүүн орнууд нь зөвхөн тус бүс нутгийнхаа хөгжлийг дээшлүүлэхийн төлөө байнга чармайдаг.

8. Под ред. Осьмовой М.Н., Бойченко А.В. Глобализация мирового хозяйства - М.: ИНФРА-М, 2006, с 147.

Дээрх жишээнүүдээс үзэхэд бүс нутгийн бүсшил нь дэлхий дахинд өрнөж буй даяаршлын эсрэг үүссэн зүйл гэдэг нь тодорхой болж байна. Энэхүү санааг мөн дараах ишлэлээс харж болох юм.

“Местная солидарность укрепляется в ответ на внешнюю угрозу, которую создает глобализация”⁹. Даяаршлын үүсгэж буй аюулын эсрэг тэмцэхийн тулд бүс нутгийн эв санааны нэгдэл нь бэхждэг.

Дүгнэлт

Судалгаа хийсэн хэмжээнд дараах дүгнэлтийг хийж байна. Орчин цагт дэлхийд маш идэвхтэй хэрэгжин хөгжиж, жилээс жилд улам олон орнуудыг хамруулж байгаа үйл явцууд бол даяаршил болон бүс нутгийн бүсшил юм. Ямар нэгэн бүлэглэлийн хүрээнд хүчээ нэгтгэн ажиллах санаачилгыг хөгжингүй гүрнүүдийн зүгээс гаргадаг нь эдгээр хоёр үзэгдлийн нийтлэг шинж чанаруудын нэг илрэл юм. Үүнээс гадна бүтээгдэхүүний чанар болон тээврийн хэрэгслүүдэд тавигдах экологийн шаардлага, харилцаа холбооны хэрэгслийн техникийн стандарт, боловсролын дипломыг олон улсад хүлээн зөвшөөрөх нь гишүүн улсуудын хувьд цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллах болзол, түлхэц бодлог. Үүнээс үзэхэд даяаршил бүс нутгийн бүсшил хоёр нь ижил төстэй, магадгүй бүс нутгийн бүсшил нь даяаршлын нэг үе шат хэмээн тодорхойлж болох боловч энэхүү үзэгдлүүд нь хоорондоо маш их ялгаатай, эсрэг шинж чанартай үйл явцууд гэсэн үзэл нь илүү үндэслэлтэй юм. Даяаршил нь худалдаа үйлдвэрлэл, техник болон соёлын үндсэн дээр тулгуурлан улсуудыг хооронд нь холбох, ижилсүүлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бол бүс нутагт нэгтгэдэг хүчин зүйлсэд нь газар зүйн байршил, соёл, түүхийн холбоо болон гадны сөрөг нөлөөнөөс улс орноо хамтран хамгаалах хүсэл, эрмэлзэл багтдаг. Иймээс бүс нутгийн бүсшил нь даяаршлын эсрэг тэмцэх, түүний нөлөөнд автахгүй байх хүсэл эрмэлзэлтэй улс орнуудын зүгээс санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм. Аливаа нэгэн бүс нутаг байгуулан хамтарснаар гишүүн улсууд нь даяаршлын бай болохоос сэргийлээд зогсохгүй дэлхийд өрсөлдөх чадвартай улс гүрэн болж хөгжих боломжтой болдог. Энэхүү судалгааны сэдэв нь шинэ,

9. Под ред. Осьмовой М.Н., Бойченко А.В. Глобализация мирового хозяйства - М.: ИНФРА-М, 2006, с 149.

Бүс нутгийн бүшил нь даяаршлын нэг хэсэг үү эсвэл түүний альтернатив уу?

олон судлаачдын маргааны шалтгаан болж их сонирхол татаж байгаа бөгөөд зохиогч миний хувьд цаашид илүү их судалгаа хийх хүсэл, төлөвлөгөөтэй байгаа болно.

Ном зүй:

1. Area Studies in the Age of Globalization, David Ludden, University of Pennsylvania, *Frontiers: The Interdisciplinary Journal of Study Abroad*, Winter 2000, 1-22.
2. La régionalisation en Europe, Gérard Marcou, Université Paris I Panthéon-Sorbonne, 1999.
3. Глобализация мирового хозяйства, под ред. Осьмовой М.Н., Бойченко А.В. - М.: ИНФРА-М, 2006
4. Процессы региональной интеграции в мировой экономике // Вестник Московского университета, серия 6, экономика. 2007. № 2.
5. Сборник трудов молодых ученых : Вып. 7 / Моск. гос. ун-т им. М. В. Ломоносова, Фак. иностр. яз. и регионоведения М. : Изд-во Моск. ун-та, 2012.

Цахим эх сурвалж:

<http://dictionary.cambridge.org>

<http://news.stanford.edu>

<http://www.bbc.com>

<http://www.larousse.fr>

<http://www.oxforddictionaries.com>

<https://www.globalpolicy.org>

<https://www.imf.org>